

## ГАРЧИГ

1. Аргачлалын тайлбар	2
2. Үндсэн үзүүлэлтүүд	4
3. Үнэ тариф, ханш	5
4. Бизнес регистрийн сан	7
5. Мөнгө, зээл, хадгаламж	8
6. Төсвийн орлого, зарлага	9
7. Хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд	12
8. Нийгмийн даатгал	15
9. Нөхөн олговор, ажилгүйдлийн даатгал	15
10. Нийгмийн халамжийн үйлчилгээ	15
11. Эрүүл мэнд	17
12. Боловсрол	18
13. Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны захиалга	22
14. Хүн амын амьжиргааны доод түвшин	25
15. Аж үйлдвэр	26
16. Тээвэр	28
17. Холбоо	29
18. Барилга	29
19. Мал аж ахуй	29
20. Газар тариалан	33
21. Мэргэжлийн хяналт шалгалт	34
22. Гэмт хэрэг	35
23. Гаалийн хорооны мэдээ	37
24. Уур амьсгалын элемент, агаар бохирдуулагч үзүүлэлтүүд	37
25. Хог хаягдлын судалгаа	38
26. Газрын нэгдмэл сангийн тайлан	38

## Аргачлалын тайлбар

### Аймгийн нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг. Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

### Үнэ, тариф

1991 оны 9-р сараас эхлэн Олон Улсын Валютын сангийн аргачиллаар хэрэглээний үнийн индексийг тооцож эхэлсэн. Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал энэ тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм. 2010 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг 214 болгон өөрчилж, 2010 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-г шинэчлэн тооцож байна.

### Ханш

Эдийн засгийн онолд ханшийг үнийн хэмжигдэхүүний нэг хэлбэр гэж үздэг. Гадаадын тодорхой ямар нэгэн валютын нэг нэгжийг худалдан авахад Монголын хэдэн төгрөг шаардлагатайг харуулсан ердийн л нэг үнэ юм. Нээлттэй эдийн засгийн хувьд үндэсний валютын ханш ялимгүй сулрахад л импортлогчид ихээхэн сандралд орж, харин экспортлогчдын олж ирсэн гадаад валютын нэг нэгжид ногдох дотоод валютын хэмжээ нэмэгдэн экспортлогчид урамших жишээтэй. Гадаад худалдаа эрхлэгчид нэг ам.доллар чухам хичнээн төгрөг байх нь хэрэгтэйгээс гадна энэ ханш маргааш, нөгөөдөр, ирээдүйд ямар байхыг мэдэх нь чухал байдаг.

### Мөнгө, зээл, хадгаламж

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд банкнаас гадуурх мөнгө, банкны касс дахь бэлэн мөнгийг оруулна. Мөнгө  $M_1$ -д харилцах дансан дахь мөнгө, иргэдийн хугацаагүй хадгаламж, банкны гадуурх бэлэн мөнгийг хамруулна. Мөнгө  $M_2$  бол мөнгө  $M_1$  болон бараг мөнгөний нийлбэр юм. Бараг мөнгөнд иргэд, байгууллагуудын хугацаатай хадгаламжууд, гадаад валютын хадгаламжийг хамруулна.

### Аж үйлдвэр

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Аж үйлдвэрийн

борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүн нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

### **Хөдөлмөр**

Ажиллагсдын тоо нь сарын эцэст бэлэн байгаа тухайн салбарын ажиллагсдын тоо юм. Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орсон.

### **Эрүүл мэнд**

Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүдийг аймгийн эрүүл мэндийн газраас сар бүр гаргаж ирүүлдэг. Эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг оны эхэнд байсан суурин хүн амын тоонд харьцуулан промилиэр буюу 1000 хүн амд ногдох хэмжээгээр гаргаж өмнөх оны түвшинтэй харьцуулан өсөлт, бууралтыг харууллаа. Зарим үзүүлэлтийг дицомилиэр буюу 10000 хүнд ногдох үзүүлэлтээр гаргадаг. Нялхсын нас баралт (нэг хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

### **Боловсрол**

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад суралцагсад, төгсөгчид, элсэгчид, багш нарын тоог сургууль, анги, хүйс, хичээлийн жилээр гаргав. БСШУЯ-наас гаргаж ҮСГ-т ирүүлдэг бүх шатны боловсролын байгууллагуудын мэдээ, тайланг авч танилцуулгад тусгаж байна. Боловсролын олон улсын стандарт ангилал нь 1997 онд шинэчлэн мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг ангиллаар боловсролын түвшинг 0-6 түвшинд ангилж байна.

### **Бизнес регистрийн сан.**

Бизнес регистрийн мэдээллийн санг 1998 онд явагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын үр дүнд тулгуурлан анх байгуулсан бөгөөд түүнээс хойш орсон өөрчлөлтийг Татварын хэлтсийн бүртгэл болон бусад байгууллагын мэдээллийг үндэслэн улирал тутам шинэчлэн тусгаж ирсэн болно. Хуулийн этгээд гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3-р зүйлийн 1-ийн 1-д заасан зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ.

### **Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн.**

Өмнөх онуудад аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг 1996 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж байсан бол 2012 оноос эхлэн 2005 оны үнээр үнэлдэг боллоо.

## НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2019 он

	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018	2019
Бэлэн хүн ам*	тоо	97342	97691	99796	101879	104238	102014
ХЗА-д бүртгэлтэй ажилгүйчүүд	тоо	1618	1781	1879	1955	1298	1202
Үүнээс эмэгтэй	тоо	1600	1014	1036	1095	755	678
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	1000	773	3182	945	1192	1526
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	888	792	675	768	818	803
Хэрэглээний үнийн индекс /өмнөх сартай харьцуулсан/	%	0.8	-0.2	1.1	0.6	1.1	0.8
Төгрөгийн зах зээлийн ханш	1\$=₮	1924.9	1998.32	2498.62	2430.35	2650.55	2735.88
Төсвийн орлого багцаар	сая.төг	24818.4	23098.8	26521.3	34302.4	38832.3	41296.4
Төсвийн зарлага багцаар	сая.төг	53040.8	50611.5	55316.2	60945.8	69883.4	65818.7
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн**	сая.төг	212701.9	105988.4	113921.2	195086.4	155474.8	184730.4
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт*	сая.төг	202501.9	191432.5	233790.4	279619.8	330941.4	367261.8
Нийт малын тоо *	мян.тол	324.2	288.4	324.2	310.9	306.0	347.4
Бойжсон төл	мян.тол	128.4	138.9	121.4	119.4	123.1	143.0
Том малын хорогдол	мян.тол	1.6	3.7	1.6	19.1	3.7	0.9
Хураасан ургац:	тн	43787.6	14178.5	42411.8	33568.2	38970.7	30962.6
Үр тариа	тн	14937.0	3852.0	18918.8	11030	10296.2	9680.1
Төмс	тн	7327.6	2931.8	7364.2	8544.8	7969.9	7281.4
Хүнсний ногоо	тн	17085.8	4695.8	14024.8	13220.6	16049.6	12254.9

\* Тухайн жилийн дүн

\*\* 2005 оны зэрэгцүүлэх үнэ


\*\*\* Төвлөрсөн төсвийн зарлага 2013 оноос 5 сайдын багцаар гардаг болсон.

## НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСАГ

### 1. ҮНЭ, ТАРИФ

2019 оны 12 дугаар сарын 21-ний байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс нь өмнөх сартай харьцуулахад 0.8 хувиар, оны эхнийхээс 5.6 хувиар тус тус өссөн байна.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн ерөнхий болон хүнсний барааны индексийн өөрчлөлт сүүлийн 12 сараар, өмнөх сартай харьцуулсан хувиар:




Өмнөх сартай харьцуулахад хүнсний гол хэрэглээ болох мах, махан бүтээгдэхүүний үнэ 0.3 хувиар /үхрийн ястай махны үнэ 1 кг нь 8000-8500 төгрөг, хонины махны үнэ 1 кг нь 7000-7800 төгрөг/ буурсан ч сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 8.7 хувиар, төмс хүнсний ногооны үнэ 12.1 хувиар тус тус өссөн нь хүнсний барааны үнийн индекс 2.0 хувиар, ерөнхий индекс 0.8 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн байна.

### Хүнсний барааны үнийн индекс, бүлгээр, сүүлийн 6 сараар, өмнөх сартай харьцуулсан хувиар

	VII.2019	VIII.2019	IX.2019	X.2019	XI.2019	XII.2019
<b>Ерөнхий индекс</b>	<b>99.7</b>	<b>99.8</b>	<b>99.6</b>	<b>99.5</b>	<b>100.3</b>	<b>100.8</b>
Хүнсний бараа	98.4	98.1	98.5	97.8	99.8	102.0
Талх, гурил, будаа	100.3	100.0	101.1	100.6	100.0	100.2
Мах, махан бүтээгдэхүүн	95.5	95.8	97.8	94.7	96.4	99.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн	96.7	99.7	101.1	102.4	108.5	108.7
Сахар, цай, жимсний чанамал	100.0	100.0	99.7	100.2	103.2	101.1
Жимс, жимсгэнэ	105.2	103.7	100.0	102.0	100.0	100.6
Төмс, хүнсний ногоо	105.0	97.8	90.5	94.6	102.4	112.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн	100.0	100.0	100.0	100.0	103.3	100.0

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн индекс, өмнөх сар=100.



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2019 оны 12 дугаар сард бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс 5.6 хувиар өслөө. Үүний дотор хүнсний барааны үнийн индекс 8.3%-иар, согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүн 2.2%, гутал хувцас, бөс барааны үнэ 5.0%, гэр ахуйн барааны үнэ 12.4%, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 3.6%, боловсролын үйлчилгээ 8.8%, зочид буудал, зоогийн газрын бүлгийн дүн 30.8 %, орон сууц, түлш, цахилгааны бүлгийн дүн 4.7%, бусад бараа, үйлчилгээний үнэ 7.8%, чөлөөт цаг, соёлын барааны бүлгийн дүн 0.1%-иар тус тус өсч, тээврийн үйлчилгээ 1.0%, холбооны үйлчилгээний бүлгийн дүн 0.6%-иар тус тус буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс,  
өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, бүлгийн дүнгээр

	I.2019	II.2019	III.2019	IV.2019	V.2019	VI.2019	VII.2019	VIII.2019	IX.2019	X.2019	XI.2019	XII.2019
Хүнсний бараа	112.2	108.6	107.8	109.2	114.0	109.9	109.5	118.3	115.6	112.7	110.4	108.3
Согтууруулах ундаа, тамхи	105.4	103.5	103.5	103.5	103.5	103.6	103.6	102.4	102.3	102.3	102.2	102.2
Хувцас гутал	105.2	106.7	106.8	106.2	106.3	106.9	106.9	107.1	107.0	105.1	104.7	105.0
Орон сууц, түлш цахилгаан	102.1	102.1	102.1	102.0	102.0	101.9	101.9	106.7	105.7	104.8	103.8	104.7
Гэр ахуйн бараа	101.0	102.4	101.7	101.4	103.2	106.3	106.5	107.0	108.7	111.0	110.5	112.4
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	117.0	117.3	115.2	112.9	112.8	113.3	116.2	110.9	109.5	108.7	105.5	103.6
Тээвэр, шатахуун	109.5	107.1	107.1	107.4	108.5	108.6	107.1	105.9	103.9	100.3	99.3	99.0
Холбооны үйлчилгээ	100.9	100.9	100.3	100.5	100.5	100.5	100.5	100.5	100.5	101.7	99.4	99.4
Соёлын бараа, үйлчилгээ	99.8	99.8	99.8	100.8	100.8	100.8	100.8	100.8	100.6	100.1	100.1	100.1
Боловсрол	113.8	113.8	113.8	113.8	113.8	113.8	113.8	108.8	108.8	108.8	108.8	108.8
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны	113.6	113.6	113.6	114.4	121.8	127.9	133.9	133.9	133.9	130.8	130.0	130.8
Бусад бараа, үйлчилгээ	100.3	100.9	101.3	102.6	104.5	104.8	105.8	105.8	105.8	106.0	106.2	107.8
Ерөнхий индекс	107.5	106.5	106.2	106.6	108.4	107.6	107.5	110.0	108.8	107.2	105.9	105.6


Гурил, гурилан бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, дээр нь төв суурин газруудад төмс, хүнсний ногоо монгол өрхийн хамгийн чухал хэрэглээ, дийлэнх өрхүүдийн амьжиргаа нь эдгээр бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай байдаг.

Үндэсний Статистикийн хороо нь 1991 оноос Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын аргачлалаар хэрэглээний үнийн индексийг тооцож эхэлсэн бөгөөд 1991 оноос хойш сагсны нэр төрөл, хэрэглээний жин, суурь үеийг 5 жил тутамд нийт 5 удаа шинэчилсэн. ҮСХ нь 2017 онд хэрэглээний сагсны нэр төрлийг аймгуудад 238 болгон нэмэгдүүлж, ӨНЭЗС-ны үр дүнгээр хэрэглээний зардлын жинг шинэчлэн хэрэглээний үнийн индексийг тооцон, нийтэд мэдээлж байна.

## 2. ХАНШ

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2020 оны 01-р сарын 5-ны байдлаар Монгол банк 2735.88 төгрөг, Голомт банк 2730 төгрөг, Худалдаа хөгжлийн банк 2731 төгрөг, ХААН банк 2730 төгрөгөөр тус тус авч байна. Монгол банкны ам.доллартай харьцах ханш 2019 оны 12-р сарын 04-наас 15.22 төгрөгөөр буюу 0.6 хувиар өсчээ. 2020 оны 01-р сарын 5-ны өдөр ам. доллар 2735.88, Евро 3051.46, Японы иень 25.35, Английн фунт 3581.95, Хятадын юань 392.29, Өмнөд Солонгосын вон 2.34, Оросын рубль 43.98, Тайваны доллар 91.04, Энэтхэгийн рупи 38.15 төгрөгийн ханштай байлаа. Нэг ам доллар 1993 онд 396.51 төгрөг, 1996 онд 693.51 төгрөг, 2000 онд 1097.0 төгрөг, 2005 онд 1121.0 төгрөгтэй тэнцүү байлаа.

01-р сарын 05-ны байдлаар



## 3. БИЗНЕС РЕГИСТРИЙН САН

2019 оны 4-р улирлын байдлаар бизнес регистрийн санд 5102 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 2603 аж ахуйн нэгж байгууллага буюу 51.4 хувь нь үйл ажиллагаа хэвийн явуулж байна. Үйл ажиллагаа явуулаагүй 2482 аж ахуйн нэгж байгаагийн 49.7 хувь нь ажлаа огт эхлээгүй, 29.5 хувь түр зогссон, 5.8 хувь нь бүрэн зогссон, 13.8 хувь нь татан буугдсан, 1.2 хувь нь бусад шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна.

**Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын тоо,  
үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумдаар, 2019 оны 4 дүгээр улирал**

Үзүүлэлтүүд	Нийт	Үүнээс						
		Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа явуулаагүй байгаа	Үүнээс:				
				эхлээгүй байгаа	түр зогсоосон	бүрэн зогсоосон	Татан буугдсан	Бусад
Дархан	4509	2331	2178	1103	627	122	297	29
Шарын гол	239	107	132	65	31	12	23	1
Орхон	131	72	59	15	29	3	12	0
Хонгор	223	110	113	50	46	6	11	0
<b>Бүгд</b>	<b>5102</b>	<b>2620</b>	<b>2482</b>	<b>1233</b>	<b>733</b>	<b>143</b>	<b>343</b>	<b>30</b>

**Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, хариуцлагын хэлбэрээр,  
2019 оны 4 дугаар улирал**

Үзүүлэлтүүд	Нийт	Үүнээс						
		Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа явуулаагүй байгаа	Үүнээс:				
				эхлээгүй байгаа	түр зогсоосон	бүрэн зогсоосон	Татан буугдсан	Бусад
Хувьцаат компани	32	30	2		1		1	
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	3764	1940	1824	857	571	108	260	28
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	78	25	53	20	20	5	8	
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	257	52	205	128	50	5	20	2
Хоршоо	163	51	112	32	42	9	29	0
Төрийн өмчит үйлдвэрийн газар	4	3	1				1	
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	11	7	4	2		1	1	
Төсөвт байгууллага	133	126	7	2			5	
Төрийн бус байгууллага	641	375	266	186	48	15	17	
Сан	5	3	2	2				
Бусад	14	8	6	4	1		1	
<b>Нийт</b>	<b>5102</b>	<b>2620</b>	<b>2482</b>	<b>1233</b>	<b>733</b>	<b>143</b>	<b>342</b>	<b>30</b>

**Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, эдийн засгийн салбараар,  
2019 оны 4 дугаар улирал**

Эдийн засгийн салбарууд	ААНБ-ын тоо
Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуй	180
Уул уурхай, олборлох үйлдвэр	19
Боловсруулах үйлдвэр	250
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	12
Барилга	155
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	888
Зочид буудал, зоогийн газар	145
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	67
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	84
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	158
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын	44
Боловсролын салбарын үйл ажиллагаа	152
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	111
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	354
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	1
<b>Бүгд</b>	<b>2620</b>

**4.МӨНГӨ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ**

Дархан-Уул аймаг дахь монгол банкны салбарын мэдээгээр 2019 онд аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 296.2 тэрбум төгрөг, үүнээс чанаргүй



зээлийн өрийн үлдэгдэл 10.98 тэрбум төгрөгт хүрчээ. 2019 оны эцэст хадгаламж 263.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**Банкны кассын орлого, зарлага, зээл, хадгаламжийн мэдээ,  
сая.төг, жил бүрийн эцсээр**

Онууд	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/ 2018	Зөрүү
Зээлийн өрийн бүх үлдэгдэл	123390.0	138233.0	216519	245606.4	196352.8	200069.5	224847.8	307502.1	296246.4	96.3	-11255.8
Үүнээс чанаргүй зээл	8235.9	1081.6	1345.8	3299.5	7222.0	8316.3	7249.5	7259.0	10977.2	151.2	3718.3
Хадгаламж	56379.9	68718.1	84884.8	97133.5	104665.9	144149.4	179602.8	235941.9	263344.3	111.6	27402.4

**5. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Санхүү төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2019 онд улс, орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 5.2 хувиар буюу 2042.8 сая төгрөгөөр давсан байна. Үүнд: орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 2.7 хувиар буюу 830.1 сая төгрөгөөр, төвлөрсөн төсвийн орлогын гүйцэтгэл 14.1 хувиар буюу 1212.7 сая төгрөгөөр тус тус давсан байна. Орлогын албан татвар 0.3 хувиар, бусад татвар, төлбөр хураамжийн төлөвлөгөө 1.4 хувиар, АТБӨЯХАТатвар 6.2 хувиар, өмчийн татвар 28.8 хувиар тус тус давсан байна.

Аймгийн нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл нь Дархан сум 4.4 хувиар буюу 248.0 сая төгрөгөөр, Шарын гол сум 1.9 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр, Хонгор сум 5.0 хувь буюу 37.9 сая төгрөгөөр, Орхон сум 12.0 хувиар буюу 28.5 сая төгрөгөөр, Хэлтэс 5.4 хувиар буюу 1718.4 сая төгрөгөөр тус тус давсан байна.

**Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, сумдаар мянган төг-өөр**

		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Төвлөрсөн төсвийн орлого	Дархан	-	-	0.0	0.0
	Хонгор	-	-	0.0	0.0
	Орхон	-	-	0.0	0.0
	Шарын гол	-	-	0.0	0.0
	Хэлтэс	8,622,000.0	9,834,688.3	114.1	1212688.3
	Дүн	8,622,000.0	9,834,688.3	114.1	1212688.3
Орон нутгийн төсвийн орлого	Дархан	5,658,229.4	5,906,263.2	104.4	248033.8
	Хонгор	758,495.9	796,406.2	105.0	37910.3
	Орхон	237,700.2	266,204.8	112.0	28504.6
	Шарын гол	514,184.9	524,052.2	101.9	9867.3
	Хэлтэс	23,463,063.8	23,968,811.3	102.2	505747.5
	Дүн	30,631,674.2	31,461,737.7	102.7	830063.5
Аймгийн төсвийн нийт орлого	Дархан	5,658,229.4	5,906,263.2	104.4	248033.8
	Хонгор	758,495.9	796,406.2	105.0	37910.3
	Орхон	237,700.2	266,204.8	112.0	28504.6
	Шарын гол	514,184.9	524,052.2	101.9	9867.3
	Хэлтэс	32,085,063.8	33,803,499.6	105.4	1718435.8
	Дүн	39,253,674.2	41,296,426.0	105.2	2042751.8

## Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, орлогын төрлөөр, мянган төг-өөр

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
ААНБ-ын орлогын албан татвар	2,300,000.0	3,161,961.9	137.5
Нэмэгдсэн өртгийн татвар	4,500,000.0	5,505,178.8	122.3
Онцгой татвар	100,000.0	15,946.0	15.9
Агаарын бохирдол	36,000.0	32,893.0	91.4
Ашигт малтмал	1,686,000.0	1,118,708.6	66.4
Ус бохирдуулсны		-	0.0
Өсөн нэмэгдэх АМНАТ			0.0
Төвлөрсөн төсвийн дүн	<b>8,622,000.0</b>	<b>9,834,688.3</b>	114.1
Татварын орлого	24,196,383.4	24,725,733.1	102.2
-орлогын албан татвар	19,125,385.4	19,186,512.7	100.3
-өмчийн татвар	1,332,110.0	1,715,766.6	128.8
-бусад татвар, хураамж	3,098,888.0	3,143,709.6	101.4
-АТБӨЯХАТ	640,000.0	679,744.1	106.2
Татварын бус орлого	2,817,104.6	3,117,818.4	110.7
ОНТөсвийн оны эхний үлдэгдэл	2,592,041.7	2,592,041.7	100.0
ОНХөгжлийн сангийн орлого	1,026,144.5	1,026,144.5	100.0
Нийт төсвийн дүн	<b>39,253,674.2</b>	<b>41,296,426.0</b>	105.2

## 6.ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЛАГА

Яам, агентлагуудаар дамжин төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудад 2019 онд улсын төсвийн санхүүжилтээр 64907.0 сая төгрөг, үндсэн, туслах үйл ажиллагааны болон бусад орлогоос 1540.0 сая төгрөг, нийтдээ 66447.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ.

### Төсвийн байгууллагуудын санхүүжилт, мян.төг-өөр

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Эзлэх хувь
Барилга, хот байгуулалтын сайд	279,956.3	279,525.9	99.8	0.4
Боловсрол, соёл ШУССайд	33,900,978.2	33,266,832.4	98.1	50.1
Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд	661,083.7	655,480.0	99.2	1.0
Эрүүл мэндийн сайд	3,273,331.5	3,217,641.6	98.3	4.8
Аймгийн засаг дарга	27,769,221.4	29,027,524.0	104.5	43.7
<b>Нийт дүн</b>	<b>65,884,571.1</b>	<b>66,447,003.9</b>	<b>100.9</b>	<b>100</b>

Төсвийн нийт санхүүжилтийн 50.1 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын үйлчилгээ, 0.4 хувийг Барилга, хот байгуулалтын сайд, 1.0 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайд, 4.8 хувийг Эрүүл мэндийн сайд, 43.7 хувийг Аймгийн засаг даргын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн байгууллагуудын нийт зарлагын 43.5 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 5.4 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал 51.0 хувийг эзэлж байна. Төсвийн байгууллагуудын бараа үйлчилгээний бусад зардалд 0.38 хувийг бичиг хэргийн зардал, 9.87

хувийг гэрэл түлш халаалтын зардал, 0.78 хувийг тээврийн зардал, 1.38 хувийг цэвэр бохир ус, 6.48 хувийг хоол, эмний зардал, 0.28 хувийг шуудан холбоо, 13.63 хувийг БГАжил үйлчилгээ, 39.56 хувийг түрээсийн болон бусад зардал, татаас болон урсгал шилжүүлэг 24.41 хувийг, урсгал засвар, эд хогшил худалдан авах, албан томилолт 3.22 хувийг эзэлж байна.

2019 онд аймгийн нийт төсвийн байгууллагууд 1775.3 сая төгрөгийн авлагатай, 786.8 сая төгрөгийн цалин, НДШ, эрүүл мэндийн даатгалын хураамжинд өглөгтэй байна.

### Төсвийн байгууллагуудын зарлага, мянган төгрөгөөр

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Боловсрол, шинжлэх ухааны сайд	33,900,978.2	33,183,136.7	97.9
Барилга, хот байгуулалтын сайд	279,956.3	278,293.0	99.4
Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд	661,083.7	627,668.2	94.9
Эрүүл мэнд, спортын сайд	3,273,331.5	3,196,901.4	97.7
Аймгийн засаг дарга	31,054,050.6	28,532,746.1	91.9
<b>Нийт зардлын дүн</b>	<b>69,169,400.3</b>	<b>65,818,745.5</b>	<b>95.2</b>
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>32,844,350.2</b>	<b>32,228,515.6</b>	<b>48.97</b>
а. Цалин, нэмэгдэл урамшуулал	29,189,786.6	28,650,576.7	43.53
б. Нийгмийн даатгалын шимтгэл	3,654,563.6	3,577,938.9	5.44
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,325,050.1</b>	<b>33,590,229.9</b>	<b>51.03</b>
Үүнээс: -гэрэл цахилгаан	564,207.1	529,638.5	1.58
-түлш халаалт	2,850,939.3	2,783,083.1	8.29
-цэвэр, бохир ус	534,252.1	463,904.7	1.38
-байрны түрээс	94,660.8	89,020.8	0.27
-бичиг хэрэг	122,087.3	127,658.7	0.38
-тээвэр	272,844.4	262,740.3	0.78
-шуудан холбоо	103,999.5	94,635.6	0.28
-хоол, эм	2,191,315.4	2,177,925.7	6.48
-эд хогшил худалдан авах	410,448.2	404,304.5	1.20
-урсгал засвар	421,643.4	400,707.3	1.19
-албан томилолт	286,975.5	279,199.9	0.83
-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	4,783,345.9	4,578,978.6	13.63
-бусад	15,102,001.0	13,198,909.3	39.29
Татаас ба урсгал шилжүүлэг	8,586,330.2	8,199,522.9	24.41

### Төсвийн авлага, өглөг, мян.төг

	Дүн	Хувь
Авлага	1,775,270.9	-
Өглөг	786.8	100.0
Үүнээс: Цалин, НДШ, ЭМД-ын хураамж	786.8	100.00
гэрэл, түлш халаалт	-	-
тээвэр, шуудан, холбоо	-	-
цэвэр бохир ус	-	-
хоол, эм	-	-
бусад	-	-

### ХОЁР. ХҮН АМ, НИЙГМИЙН БАЙДАЛ

#### 2.1 ӨРХИЙН ТОО

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	28340	27993	27433	27906	28048	29971	29678	30133	30503	28815
Дархан	23457	23154	22789	23241	23349	25216	24934	25411	25767	24304
Хонгор	1642	1610	1529	1539	1587	1584	1614	1608	1605	1548
Орхон	979	970	965	957	931	977	962	987	1000	940
Шарын гол	2262	2259	2150	2169	2182	2194	2168	2127	2131	2023

## 2.2 Хүн ам

		2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Дархан-Уул аймаг	Бүгд	95043	93137	92735	93554	97342	97691	99796	101879	104238	102014
	эрэгтэй	46180	45335	45203	45470	47619	47955	48996	49915	51226	50125
	эмэгтэй	48863	47802	47532	48084	49723	49736	50800	51964	53012	51889
Дархан	Бүгд	77547	75494	75644	76428	79938	80652	82247	84256	86749	85066
	эрэгтэй	37407	36494	36589	36831	38750	39222	39993	40852	42212	41393
	эмэгтэй	40140	39000	39055	39597	41188	41430	42254	43404	44537	43673
Хонгор	Бүгд	5796	5856	5693	5759	6101	5970	6184	6217	6115	5869
	эрэгтэй	2942	2959	2896	2943	3142	3099	3215	3250	3227	3110
	эмэгтэй	2854	2897	2797	2816	2959	2871	2969	2967	2888	2759
Орхон	Бүгд	3277	3356	3277	3240	3155	3076	3186	3226	3300	3213
	эрэгтэй	1606	1643	1631	1610	1600	1568	1632	1659	1683	1635
	эмэгтэй	1671	1713	1646	1630	1555	1508	1554	1567	1617	1578
Шарын гол	Бүгд	8423	8431	8121	8127	8148	7993	8179	8180	8074	7866
	эрэгтэй	4225	4239	4087	4086	4127	4066	4156	4154	4104	3987
	эмэгтэй	4198	4192	4034	4041	4021	3927	4023	4026	3970	3879

## 2.3 СУУРИН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР

	2016			2017			2018			2019		
	бүгд	эм	эр	бүгд	эм	эр	бүгд	эм	эр	бүгд	эм	эр
<b>Бүгд</b>	99796	50800	48996	101879	51964	49915	104238	53012	51226	102014	51889	50125
<b>&gt;1</b>	2088	965	1123	2039	1003	1036	2527	1176	1351	2464	1177	1287
<b>1-4</b>	9681	4781	4900	9850	4786	5064	9823	4740	5083	9461	4515	4946
<b>5-9</b>	10130	4898	5232	10738	5245	5493	11280	5552	5728	11393	5609	5784
<b>10-14</b>	6835	3343	3492	7238	3550	3688	7940	3861	4079	8728	4241	4487
<b>15-19</b>	7622	3809	3813	7487	3722	3765	7191	3556	3635	6546	3238	3308
<b>20-24</b>	8100	4013	4087	7763	3886	3877	7788	3982	3806	7122	3589	3533
<b>25-29</b>	9535	4541	4994	9710	4657	5053	9269	4454	4815	8331	4044	4287
<b>30-34</b>	7986	3976	4010	8194	4059	4135	8654	4202	4452	8529	4154	4375
<b>35-39</b>	7533	3859	3674	7607	3908	3699	7575	3845	3730	7316	3717	3599
<b>40-44</b>	7099	3670	3429	7239	3744	3495	7174	3663	3511	6959	3575	3384
<b>45-49</b>	6251	3299	2952	6250	3284	2966	6438	3417	3021	6314	3301	3013
<b>50-54</b>	5812	3208	2604	5897	3234	2663	5874	3170	2704	5764	3086	2678
<b>55-59</b>	4238	2377	1861	4560	2550	2010	4922	2771	2151	4975	2820	2155
<b>60-64</b>	2599	1489	1110	2844	1639	1205	3102	1807	1295	3372	1967	1405
<b>65-69</b>	1683	1001	682	1719	1027	692	1884	1099	785	1954	1136	818
<b>70-74</b>	1148	677	471	1187	712	475	1224	748	476	1215	735	480
<b>75-79</b>	822	457	365	912	511	401	898	511	387	885	530	355
<b>80-84</b>	413	268	145	396	256	140	415	266	149	427	260	167
<b>85-89</b>	153	114	39	179	134	45	187	133	54	197	144	53
<b>90-94</b>	50	39	11	45	36	9	45	37	8	45	36	9
<b>95-99</b>	16	14	2	22	19	3	26	20	6	14	12	2
<b>100+</b>	2	2	0	3	2	1	2	2	0	3	3	0

## 2.4 СУУРИН ХҮН АМЫН ТОО, БАГААР, ХҮЙСЭЭР

Сум, багийн нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо		
		Бүгд	эмэгтэй	эрэгтэй
1-р баг	927	3820	1915	1905
2-р баг	1248	4493	2269	2224
3-р баг	1386	5133	2577	2556
4-р баг	984	2992	1430	1562
5-р баг	1282	4802	2373	2429
6-р баг	1225	4830	2402	2428
7-р баг	1564	5927	2971	2956
8-р баг	1936	7064	3430	3634
9-р баг	1608	5440	2547	2893
10-р баг	1574	5577	2663	2914
11-р баг	1343	4169	1954	2215
12-р баг	1171	3767	1777	1990
13-р баг	1279	4373	2097	2276
14-р баг	1556	5212	2469	2743
15-р баг	2493	8368	4182	4186
16-р баг	1259	3916	1811	2105
Өргөө баг	573	1991	980	1011
Малчин баг	896	3192	1546	1646
<b>Дархан сумын дүн</b>	<b>24304</b>	<b>85066</b>	<b>41393</b>	<b>43673</b>
1-р баг, Баян-Өлзийт	699	2558	1277	1281
2-р баг, Энхтал	241	655	358	297
<b>Орхон сумын дүн</b>	<b>940</b>	<b>3213</b>	<b>1635</b>	<b>1578</b>
1-р баг	552	2378	1243	1135
2-р баг	499	1838	1014	824
3-р баг, Салхит баг	497	1653	853	800
<b>Хонгор сумын дүн</b>	<b>1548</b>	<b>5869</b>	<b>3110</b>	<b>2759</b>
1-р баг, Хайрхан	860	3160	1578	1582
2-р баг, Дархан	550	2128	1064	1064
3-р баг, Санжинт	613	2578	1345	1233
<b>Шарын гол сумын дүн</b>	<b>2023</b>	<b>7866</b>	<b>3987</b>	<b>3879</b>
<b>Аймгийн дүн</b>	<b>28815</b>	<b>102014</b>	<b>50125</b>	<b>51889</b>

## 2.5 ХҮН АМЫН ЕРДИЙН БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

2019 он

	Бүгд	Дархан	Хонгор	Орхон	Шарын гол
Төрж бүртгүүлсэн хүүхэд	2525	2127	123	79	196
Нас баралт	643	530	32	28	53
Цэвэр өсөлт	1882	1597	91	51	143
Бүртгүүлсэн гэр бүлийн тоо	760	643	43	14	40
Цуцалсан гэр бүлийн тоо	177	172	2	0	3
Үрчлэгдсэн хүүхдийн тоо	36	29	5	0	2
Шилжиж ирсэн хүн ам	1978	1769	84	48	77
Шилжиж явсан хүн ам	2120	1808	120	66	125

## 2.6 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН БҮС НУТГААР 2018 ОНЫ ДҮН


	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	Бүгд
Шилжиж ирсэн	332	466	1093	70	814	2775
Шилжиж явсан	140	244	736	59	421	1600
Механик өсөлт	192	222	357	11	393	1175

## НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2019 ОН

	Бүгд	Дархан	Хонгор	Орхон	Шарын гол
Өрх толгойлсон	3898	3158	205	129	406
эрэгтэй	784	616	76	30	62
эмэгтэй	3114	2542	129	99	344
ихэр хүүхэдтэй өрхийн тоо	355	298	17	13	27
18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо	1233	900	147	55	131
4 хүүхэдтэй өрхийн тоо	937	708	95	44	90
5 хүүхэдтэй өрхийн тоо	197	120	35	6	36
6 хүүхэдтэй өрхийн тоо	72	52	12	4	4
7 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн	27	20	5	1	1
Өндөр настай ганц бие өрх	1689	1501	43	59	86
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	4512	3467	213	147	685
Бүтэн өнчин хүүхэд	88	72	10	4	2
Хагас өнчин хүүхэд	796	583	90	42	81
18 хүртэл насны хүүхэдтэй гэр бүлгүй хүний тоо	2301	1890	207	100	104
Үүнээс: эхийн тоо	1573	1263	129	86	95

2019 оны эцсийн байдлаар нийт хүн амын 74.1 хувийг хөдөлмөрийн насны хүн ам, 15 хүртэл насны хүүхэд 15.2 хувийг, өндөр настан 10.7 хувийг эзлэж байна.

## 2019 он



## 2.2 НИЙГМИЙН ДААТГАЛ

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны байдлаар нийгмийн даатгалын санд 56632.6 сая төгрөгийн сан бүрдүүлж, 14632 хүнд 67256.0 сая төгрөгийн тэтгэвэр, 9525 хүнд 4460.5 сая төгрөгийн тэтгэмж, 1722 хүний үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд 4290.1 сая төгрөг олгожээ.

### Нийгмийн даатгалын сан, сая төгрөгөөр

		Орлого	Зарлага	Хүний тоо
Тэтгэврийн даатгалын сан		36027.7	67256.0	14632
Үүнээс	Өндөр насны тэтгэвэр	0.0	54034.9	11285
	Тахир дугуугийн тэтгэвэр	0.0	7542.2	2206
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	0.0	2124.4	650
	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр	0.0	3554.4	491
Тэтгэмжийн даатгалын сан		4062.0	4460.5	9525
ҮОМШӨ-ний даатгалын сан		5165.4	4290.1	1722
Ажилгүйдлийн даатгалын сан		944.1	1784.6	918
Эрүүл мэндийн даатгалын сан		10433.4	0.0	0
Дүн		56632.6	77791.24	26797

### 2.3 НӨХӨН ОЛГОВОР, АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН.

2019 оны байдлаар 918 хүнд 1748.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

### НӨХӨН ОЛГОВОР, АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

	Санхүүжилт		Зарцуулалт	
	Орлого, мян.төг	Хүний тоо	Зарлага, мян.төг	Хүний тоо
Ажилгүйдлийн тэтгэмжинд	1784593.4	918	1784593.4	918
Мэргэжлийн болон давтан		-		
Нөхөн олговорт		-		
Дүн	1784593.4	918	1784593.4	918

### 2.4 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН.

2019 онд нийгмийн халамжийн санд 13.8 тэрбум төгрөгийн сан бүрдүүлж, 2003 хүнд 1464.9 сая төгрөгийн тэтгэмж, 1922 хүнд 3571.3 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр олгожээ.

**Нийгмийн халамжийн сан, мянган төг-өөр**

		Санхүүжилт	Зарцуулалт	Хүний тоо
Бүгд		<b>14,062,516.8</b>	<b>13,821,529.4</b>	<b>43,096</b>
<b>Халамжийн тэтгэвэр</b>		<b>3,571,317.4</b>	<b>3,571,317.4</b>	1,922
<b>Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж</b>		<b>1,485,436.0</b>	<b>1,464,907.19</b>	<b>2,003</b>
Үүнээс	Ахмад настныг асарч буй иргэнд		695,214.3	1,048
	ХБ иргэнийг асарч буй иргэнд		353,560.1	512
	Хүүхэд асар ХБ		355,231.2	376
	Байнгын асаргаа шаардлагатай ХБ иргэн		298.0	1
	Бүтэн өнчин хүүхэд болон ахмад настныг асарч буй иргэнд		2,526.8	4
	Гэр бүлийн тухай хуулийн 25.5 заасан болон		13,427.2	15
	Бүтэн өнчин хүүхэд үрчилж авсан болон хүүхдийг асран хамгаалж байгаа иргэнд		44,649.7	47
<b>НХДТ шаардлагатай иргэнд үзүүлэх ХМ тусламж</b>			<b>1,020,436.8</b>	<b>1,862</b>
Үүнээс	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн		19,200.0	16
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрх		27,600.0	23
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр ороггүй иргэн		27,600.0	23
	Амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх		1,200.0	1
	16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж		668,596.8	383
	16 ба түүнээс дээш насны байнгын асаргаа шаардлагатай иргэнд олгох мөнгөн тэтгэмж		276,240.0	1,416
<b>Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж</b>			<b>3,651,447.2</b>	<b>9,903</b>
Үүнээс	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж		2,951,459.6	6,756
	Жирэмсэн эхийн тэтгэмж		398,801.0	2,900
	Ихэр хүүхдийн тэтгэмж		50,000.0	25
	3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон		251,186.6	222
<b>Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ</b>		<b>1,116,314.0</b>	<b>1,111,337.7</b>	<b>7,926</b>
<b>Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт</b>		<b>1,025,738.0</b>	<b>1,015,171.8</b>	<b>6,021</b>
<b>Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт</b>		<b>106300.0</b>	<b>102,123.6</b>	<b>51</b>
<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт</b>		<b>301470.0</b>	<b>299,082.6</b>	<b>1,579</b>
<b>Насны хишиг</b>		<b>752000.0</b>	<b>747,500.0</b>	<b>4,852</b>
<b>Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж</b>		<b>891300.0</b>	<b>887,900.0</b>	<b>6,886</b>



## 2.5 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эмчлэгдсэн өвчтөний тоо 1.4 хувиар буурч, урьдчилан сэргийлэх тарилга 17.2 хувиар, амбулаторийн үзлэг 12.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн өнгөрсөн оны энэ үеэс халдварт менингит, шигеллэз, сальмонеллэз, улаан эсэргэнэ, ёлом, тэмбүү, заг хүйтэн, салхинцэцэг, мөөгөнцөр, трихомониаз зэрэг өвчнүүд өсч, гепатит, улаанууд, хамуу, гахай хавдар, энтеровирус, бруцеллэз шинэ сүрьеэ, тус тус буурсан байна. Нийт халдварт өвчлөлийн 34.3 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 8.8 хувийг шинэ сүрьеэ эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үед 1192 хүн халдварт өвчнөөр өвчилж байсан бол энэ онд 1526 болж 334 тохиолдлоор өссөн байна.

### Эрүүл мэндийн үзүүлэлтүүд

	2018 он	2019 он	<u>2019</u> 2018 %
Амбулаторийн үзлэг	609829	685304	112.4
Урьдчилан сэргийлэх үзлэг	227817	264760	116.2
Бүртгэгдсэн өвчлөл бүгд	58165	69404	119.3
Урьдчилан сэргийлэх тарилга	18386	21551	117.2
Ор хоног ашиглалт	222557	219130	98.5
Эмчлэгдсэн өвчтөн	31112	30687	98.6
Амьд төрсөн хүүхэд	2408	2390	99.3
Шинэ жирэмсэн бүгд	2446	2158	88.2
Бүх нас баралт	572	524	91.6
Эмнэлгийн нас баралт	87	98	112.6
Хоног болоогүй нас баралт	32	34	106.3
Гэрийн нас баралт	485	426	87.8
0-15 насны нас баралт	36	27	75.0
0-1 нас баралт	26	18	69.2
Нярайн нас баралт	19	16	84.2
0-5 нас баралт	33	23	69.7
Эхийн нас баралт	2	0	0.0
Задлан шинжилгээ	61	68	111.5
Үндсэн оношийн зөрөө	2	6	300.0

### Халдварт өвчин гаралт

	2018 он		2019 он		<u>2019</u> 2018
	Тоо	промилль	тоо	промилль	
Шигеллэз /Цусан суулга/	10	1	20	1.9	200.0
Менингет	0	0.0	1	0.1	0.0
Сальмонеллэз	0	0.0	1	0.1	0.0
Хачигт рекиттиез	0	0.0	0	0.0	0.0
хоолны хордлого	0	0.0	0	0.0	0.0
улаан эсэргэнэ	30	2.9	63	6.1	210.0
Улаан бурхан	-	-			0.0
Хумхаа	-	-			0.0
Хамуу	3	0.3	0	0.0	0.0
энтеровирус 71	315	30.6	142	13.8	45.1
ёлом	0	0.0	2	0.2	0.0
хачигт энцефалит	1	0.1	1	0.1	100.0
улаанууд	1	0.1	0	0.0	0.0
салхинцэцэг	309	30.1	612	59.5	198.1
гепатит	10	1.0	7	0.7	70.0
гахай хавдар	22	2.1	18	1.8	81.8
бруцеллэз	2	0.2	0	0.0	0.0
тэмбүү	117	11.4	174	16.9	148.7
заг хүйтэн	51	5.0	76	7.4	149.0
трихомониаз	80	7.8	117	11.4	146.3
мөөгөнцөр	99	9.6	157	15.3	158.6
шинэ сүрьеэ	142	13.8	135	13.1	95.1
халдварын гаралттай суулгац	0	0.0		0.0	0.0
<b>дүн</b>	<b>1192</b>		<b>1526</b>		<b>128.0</b>

## БОЛОВСРОЛ

### Сургуулийн өмнөх боловсрол

2019-2020 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 45 цэцэрлэгийн 269 бүлэгт 977 багш, ажиллагсад ажиллаж, 8415 хүүхэд суралцаж байгаагаас шинээр элссэн 2969 хүүхэд байна.

### Цэцэрлэгийн судалгаа

№	цэцэрлэгүүд	Өмчийн хэлбэр	Онцлог	Бүлгийн тоо	Хүүхдийн тоо	Үндсэн багшийн тоо
1	1-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	223	7
2	2-р цэцэрлэг	төрийн	ердийн	5	122	5
3	3-р цэцэрлэг	төрийн	ердийн	8	261	9
4	4-р цэцэрлэг	төрийн	ердийн	12	407	13
5	5-р цэцэрлэг	төрийн	ердийн	12	431	13
6	6-р цэцэрлэг	төрийн	ердийн	8	292	9
7	7-р цэцэрлэг	төрийн	ердийн	13	380	14
8	8-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	188	7
9	9-р цэцэрлэг	төрийн	ердийн	8	231	7
10	10-р цэцэрлэг	төрийн	24 цагийн	8	291	13
11	11-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	206	7
12	12-р цэцэрлэг	төрийн	ердийн	11	373	12
13	13-р цэцэрлэг	төрийн	ердийн	11	436	12
14	14-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	179	6
15	15-р цэцэрлэг	төрийн	24цагийн	12	388	14
16	16-р цэцэрлэг	төрийн	ердийн	5	163	4
17	17-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	179	7
18	18-р цэцэрлэг	төрийн	ердийн	11	386	12
19	19-р цэцэрлэг	төрийн	ердийн	4	142	5
20	21-р цэцэрлэг	төрийн	ердийн	12	372	13
21	22-р цэцэрлэг	төрийн	ердийн	12	418	13
22	23-р цэцэрлэг	төрийн	ердийн	8	275	9
23	24-р цэцэрлэг	төрийн	ердийн	4	153	5
24	25-р цэцэрлэг	төрийн	ердийн	4	154	5
25	26-р цэцэрлэг	төрийн	ердийн	5	160	6
26	27-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	204	6
27	28-р цэцэрлэг	төрийн	ердийн	6	158	6
28	20-р цэцэрлэг	хувийн	ердийн	2	38	2
29	Бамбарууш	хувийн	ердийн	3	59	2
30	Бурхантын жаргалант	хувийн	ердийн	2	37	2
31	Жаргалтай үрс	хувийн	ердийн	2	50	2
32	Кидстаун	хувийн	ердийн	2	45	2
33	Номин	хувийн	ердийн	3	83	3
34	Солонго	хувийн	ердийн	4	100	4
35	Сүмдарьцэцэг	хувийн	ердийн	5	144	5
36	Тогдгор жаалууд	хувийн	ердийн	1	32	1
37	Төгс ундраа	хувийн	ердийн	4	84	3
38	Хааны хүүхдүүд	хувийн	ердийн	4	96	4
39	Цоглог жаалууд	хувийн	ердийн	1	32	1
40	Өсөх ирээдүй	хувийн	ердийн	6	147	7
41	Өсөх нахиа	хувийн	ердийн	3	64	3
42	Гоё	хувийн	ердийн	2	40	2
43	Нарны цацраг	хувийн	ердийн	2	35	2
44	Шинэ алхам	хувийн	ердийн	4	78	5
45	Анар	хувийн	ердийн	4	79	3
	Дүн			269	8415	292

### Бүлгийн үзүүлэлт

Үзүүлэлт	Бүлгийн тоо	Яслийн	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Бэлтгэл	Холимог	Ээлжийн	Нүүдэлчин
Дүн	269	0	72	60	68	63	3	1	2

## Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд

	2014-2015 оны хичээлийн жил	2015-2016 оны хичээлийн жил	2016-2017 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил	2019-2020 оны хичээлийн жил
Цэцэрлэгийн тоо	37	41	43	43	45	45
Бүлгийн тоо	214	238	249	257	261	269
Нийт ажиллагсад	754	846	846	928	947	977
Үүнээс: Багш , эрхлэгч	508	564	593	585	622	637
бусад ажиллагсад	246	282	318	343	325	340
бүх хүүхэд	6415	7403	7852	8273	8513	8415
Үүнээс:яслийн	313	386	495	473	0	0

## Ерөнхий боловсролын сургууль

2019-2020 оны хичээлийн жилд өдрөөр 23 сургууль, лицей 2 сургууль, орой болон эчнээгээр 1, дүйцсэн хөтөлбөрөөр 1 сургууль нийт 27 ЕБСургууль байна. Бага ангийн 353 бүлэгт 11291, суурь боловсрол 250 бүлэгт 7151, бүрэн дунд 140 бүлэгт 3632 хүүхэд, нийт бүлэгт 22074 хүүхэд суралцаж байгаагийн 11019 нь буюу 49.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна. 2019-2020 оны хичээлийн жилд 1-р ангид 2485, 2-5-р ангид 8806, 6-9-р ангид 7151, 10-12-р ангид 3632 хүүхэд суралцаж байна.

2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 167, бүтэн өнчин 68 хүүхэд суралцаж, 589 хүүхэд дотуур байранд амьдарч байна. Энэ хичээлийн жилд малчдын 269 хүүхэд дотуур байранд амьдарч байна.

## ЕБС-д суралцагчдын тоо, сургуулиар

2019-2020 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагсадын тоо 22074 байна.

№	Сургуулиуд	2018-2019 он				2019-2020 он				Хувь
		1-5 анги	6-9 анги	10-12 анги	Бүгд	1-5 анги	6-9 анги	10-12 анги	Бүгд	
1	1-р сургууль	422	273	131	826	481	251	120	852	103.1
2	Ирээдүй-2	659	373	154	1186	650	435	196	1281	108.0
3	4-р сургууль	541	347	123	1011	553	364	130	1047	103.6
4	6-р сургууль	177	103	32	312	174	103	50	327	104.8
5	8-р сургууль	212	131	56	399	212	119	62	393	98.5
6	9-р сургууль	943	512	227	1682	1032	586	265	1883	112.0
7	11-р сургууль	137	86	43	266	138	92	44	274	103.0
8	14-р сургууль	221	128	64	413	204	140	62	406	98.3
9	15-р сургууль	1069	646	240	1955	1076	686	323	2085	106.6
10	18-р сургууль	559	299	182	1040	566	341	216	1123	108.0
11	Жигүүр цогцолбор	811	453	220	1484	816	481	280	1577	106.3
12	Од цогцолбор	1754	951	317	3022	1838	1035	413	3286	108.7
13	Оюуны ирээдүй	2270	1341	508	4119	2332	1551	651	4534	110.1
14	ТИС лицей	0	58	47	105	0	48	83	131	124.8
15	ХААИС лицей	0	6	44	50	0	0	56	56	112.0
16	Энэрэл	120	97	17	234	118	103	4	225	96.2
17	19-р сургууль	308	130	55	493	271	118	64	453	91.9
18	24-р сургууль	84	47	25	156	69	23	31	123	78.8
19	29-р сургууль	0	0	34	34	0	9	47	56	164.7
20	22-р сургууль	111	10	0	121	90	15	0	105	86.8
21	Дархан эмгати	0	234	159	393	0	241	176	417	106.1
22	Монгол Оюу	173	103	33	309	219	125	51	395	127.8
23	Союз	84	35	8	127	95	43	21	159	125.2
24	Цайхун	94	67	27	188	171	92	39	302	160.6
25	30-р сургууль	0	15	66	81	0	9	177	186	229.6
26	Насан туршийн боловсролын төв	53	97	45	195	26	88	38	152	77.9
27	Шинэ алхам	101	0	0	101	160	53	33	246	243.6
	<b>Бүгд</b>	<b>10903</b>	<b>6542</b>	<b>2857</b>	<b>20302</b>	<b>11291</b>	<b>7151</b>	<b>3632</b>	<b>22074</b>	<b>108.7</b>

## ЕБС-ын багш, ажилчдын тоо, сургуулиудаар

№	Сургуулиуд	2018-2019 он				2019-2020 он			
		Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс		
			Үндсэн багш	Цагийн багш	Бусад		Үндсэн багш	Цагийн багш	Бусад
1	1-р сургууль	75	51	0	24	70	19	0	51
2	Ирээдүй-2	95	63	0	32	93	60	0	33
3	4-р сургууль	81	58	0	23	83	59	1	23
4	6-р сургууль	37	20	0	17	38	20	1	17
5	8-р сургууль	41	24	0	17	44	24	0	20
